АЖЛЫН НӨХЦӨЛ

ХЭСЭГ-1: Ажлын даалгавар болон үйлчилгээний цар хүрээ

1. **Төслийн тодорхойлолт**
2. **Гүйцэтгэх ажлын дэлгэрэнгүй**
3. **Төлбөрийн хуваарь**

ХЭСЭГ-2: Зураг төслийн даалгавар

1. **Төслийн тодорхойлолт**
2. **Зураг төслийн ажлын хамрах хүрээ**
3. **Зураг төслийн ажлын үе шат**
4. **Зураг төслийн ажлын хуваарь**
5. **Зураг төслийн ажлын даалгавар**
6. **Гүйцэтгэгчийн хариуцлага**
7. **Нууцлал**

Хавсралтууд:

Хавсралт-1. Хоол үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн байгуулалт

Хавсралт-2. Барилгын техник үзлэгийн дүгнэлт ба ажлын төлөвлөгөө

Хавсралт-3. Хоол үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн жагсаалт

ХЭСЭГ-1: АЖЛЫН ХАМРАХ ХҮРЭЭ

1 Төслийн тодорхойлолт

1.1 Төслийн байршил

- 9-р сургууль: Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 6-р хороо, 9-р сургууль
- 40-р сургууль: Улаанбаатр хот, Баянгол дүүрэг, 15-р хороо, 40-р сургууль
- 48-р сургууль: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 1-р хороо, 48-р сургууль

1.2 Төслийн товч мэдээлэл

Энэхүү зураг төслийн ажлын зорилго нь **Монгол улсын ЕБС-ийн хоол үйлдвэрлэл үйлчилгээний орчныг сайжруулах, чадавхыг бэхжүүлэх төсл**ийн хүрээнд дээр дурдсан сургуулиудын “Гал тогоо болон хооллох танхим гэх зэрэг хоол үйлдвэрлэл, үйлчилгээний байгууламж”ийг шинэчилж засварлах ажил юм.

※ Дээрх гурван сургуулийн зураг төслийн ажлыг гэрээний хугацаанд зэрэг гүйцэтгэнэ.

Байгууламжийг шинэчлэн засварлах барилгын ажил нь доор дурдсан ажлуудаас бүрдэнэ:

- Засварын ажил – дотор ханыг нураах эсвэл угсрах, одоо байгаа барилгын заслыг шинэчлэх, засварлах болон бусад ажил
- Агааржуулалт, халаалтын системийг засварлах эсвэл сайжруулах
- Цахилгааны ажил – засварын ажилтай холбогдох цахилгааны ажил
- Ус хангамж, ус зайлуулах болон ариун цэврийн шугам хоолой
- Боловсрол, шинжлэх ухааны яамнаас шаардсан бусад ажил

1.3 Төслийн хүрээнд хийгдэх ажлын хүрээ

Гүйцэтгэгч ажлын хүрээ нь зураг төслийн ажил гүйцэтгэх ба энэхүү баримт бичиг заасан ажлыг гүйцэтгэнэ. Илүү дэлгэрэнгүй мэдээллийг **Хавсралт-1 Хоол үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн байгуулалт**аас үзнэ.

1.3.1 Төслийн онцлог

Гүйцэтгэгч нь Монгол улсын дүрэм, стандартад нийцүүлэн өгөгдсөн талбай болон цахилгаан, инженерийн шугам сүлжээний засвар шинэчлэлийн ажлын зураг төслийг гүйцэтгэхэд одоо байгаа болон шинээр суурилуулах тоног төхөөрөмжийн зохистой ашиглалтыг бодолцоно.

Гүйцэтгэгч нь зураг төслийн ажлын судалгааг нарийвчлан хийж, техникийн болон үнийн саналыг боловсруулах ба гүйцэтгэлийн явцад хийх чанарын хяналт болон засвар шинэчлэлийн ажлын төлөвлөгөөг зураг төслийн ажлын төлөвлөгөөнд уялдуулж хугацааг сайтар тооцох шаардлагатай.

Гүйцэтгэгч техникийн болон үнийн саналыг танилцуулахдаа Ажил гүйцэтгэх урьдчилсан график төлөвлгөөг Барилгын засвар шинэчлэлийн ажлын ерөнхий төлөвлөгөөнд уялдуулсан байдлаар танилцуулна.

Тус ажлын гэрээг хатуу үнийн /өөрчлөхгүй/ дүнгээр хийх тул засвар шинэчлэлийн ажилд шаардлагатай бүхий л үйл ажиллагааг төлөвлөж тооцох шаардлагатай. Барилгын ажлыг гүйцэтгэх явцад гэрээт ажил болон үнэд өөрчлөлт орох боломжгүйг ойлгож тооцсон байх шаардлагатай.

1.3.2 Ажлын шаардлага

Төслийн гол зорилго нь доорх хүснэгтэд заасан шаардлагыг хангасан засвар шинэчлэлийн ажлыг гүйцэтгэх явдал юм.

1.3.3 Ажлын цар хүрээ

Зураг төслийн ажлын хүрээнд хийгдэх засвар шинэчлэлийн ажлын хүрээ

Ангилал	Ажил	Обьект	Ажлын дэлгэрэнгүй	Жич
Нураах, угсрах ажил	Нураах	Хана	Тодорхой байрлал дахь хананууд	Эскиз загвар зургаас харна.
	Угсрах	Хана	Тодорхой байрлал дахь хананууд	
Засвар Шинэчлэл	Дотоод засал	Өрөөнүүдийн дотоод засал	Тохирсон зөв аргаар засварлана.	Барилгын техник үзлэгээр илэрсэн доголдлуудыг засах
	Архитектур	Байгуулалт	Хавсралт 1,2 –т заасны дагуу давхрын байгуулалт гаргах	Барилгын бусад деталыг тойм байдлаар тодорхойлсон ба Гүйцэтгэгч шаардлагатай бүх ажлыг нарийвчилж зургийн ажилд тусгана. Эскиз загвар зургаас харна.
	Цахилгаан	Хуваарилах самбар	Хуваарилах самбарыг тусад нь суурилуулна. Кабель утсыг далд байдлаар шийднэ.	
		Гэрэлтүүлэг	Өрөөнүүдийн гэрэлтүүлгийг өөрчлөх(шаардлагатай бол)	
		Газардуулга	Бүх цахилгаан төхөөрөмжид газардуулга хийх	
	Механик, сантехник, агааржуулалт	Гал тогоо, агуулах, хооллох танхим	Сорох шүхэр (Hood), агааржуулалт, халаалт, өрөөнүүдийн агаарын солилцоог сайжруулах байдлаар шийдэх	

			Төлөвлөгөөний дагуу усан хангамж, ус зайлуулах шугамыг шилжүүлэх	

1.3.4 Төсөв тооцоо

Гүйцэтгэгч нь Ажлын зургийн дагуу Засварын ажлын төсөвт өртөг ба засварын ажлын тоог боловсруулж өгнө. Төсвийг эрх бүхий төсөвчнөөр батлуулсан байх шаардлагатай.

2. Гүйцэтгэх ажлын дэлгэрэнгүй

Зураг төслийг гүйцэтгэх ажлын тоо болон зардлын тооцоог гаргахын өмнө заавал төслийн газар дээр очиж үзэх, хийх ажлыг уналттай таазаар далдалсан байсан ч хэмжиж үзсэн байх шаардлагатай. Засвар шинэчлэлийн хүрээнд гүйцэтгэх ажлын бүхий л зардлыг засварын ажлын нийт төсөвт өртөгт багтааж тооцсон байна.

※ Гүйцэтгэгч дэлгэрэнгүй шаардлагатай танилцахын тулд Хавсралтуудыг үзнэ үү.

※ Энэхүү ажлын задаргаа нь тойм байдлаар гарсан болно. Гүйцэтгэгч нь Захиалагчтай засварын ажлын өөрчлөлт, зураг төслийн талаар дэлгэрэнгүй зөвшилцөж, баталгаажуулсан байна.

3. Төлбөрийн хуваарь

Төлбөрийг дараах хуваарийн дагуу хийнэ.

3.1 Гэрээний үнийн дүнгийн 30 хувьтай тэнцэх хэмжээний мөнгийг батлагдсан үндсэн зураг(BD)-ийг захиалагчид ирүүлсний дараа 5 хувийг нь хасаж төлнө.

3.2 Гэрээний үнийн дүнгийн 70 хувьтай тэнцэх хэмжээний мөнгийг батлагдсан эцсийн нарийвчилсан зураг, техникийн тодорхойлолт(FD)-ыг захилагчид ирүүлсний дараа 5 хувийн хадгаламжийг хасаж төлнө.

3.3 Нөхөн төлбөр

Гүйцэтгэгч гэрээний дагуу хүлээсэн үүргээ биелүүлээгүй, Төслийн хөтөлбөрийг хойшлуулсан тохиолдолд гэрээлэгч нь энэхүү гэрээний дагуу бусад нөхөн төлбөрийг хохироохгүйгээр 0.1-тай тэнцэх хэмжээний нөхөн төлбөрийг бэлэн мөнгөөр төлнө. Хугацаа хоцорсон өдрийн гэрээний үнийн дүнгийн хувь, гэрээний үнийн дүнгээс 10 хувийг гэрээний үнийн дээд хязгаарт тооцно.

3.4 Гүйцэтгэгчийн банкны данс

- Төлбөрийн данс:

- Гадаад валют: [дансны нэр, дугаарыг оруулна уу].

- Төгрөг: [дансны нэр, дугаарыг оруулна уу]

3.5 Баталгаа

Агуулга	Хэмжээ	Хугацаа	Хадгаламж	Тайлбар
Тендерийн баталгаа	Тендерийн үнийн дүнгийн **0.5%**	3 сар	Доор тайлбарласны дагуу	
Гүйцэтгэлийн баталгаа	Гэрээний үнийн дүнгийн **3%**	Гэрээний хугацаа	Доор тайлбарласны дагуу	
Хадгаламжийн барьцаа	Гэрээний үнийн дүнгийн **5%**		Доор тайлбарласны дагуу	Ажил дууссаны дараа буцаан олгоно.

※ Хадгаламжийн барьцаа нь Монгол Улсын банк эсвэл Засгийн газрын бондын баталгаа болно.

Хавсралт

Хавсралт 1. Хоол үйлвэрлэлийн тоног төхөөрөмжийн байгуулалт

Хавсралт 2. Барилгын техник үзлэгийн дүгнэлт ба хийгдэх ажлын төлөвлөгөө

Хавсралт 3. Хоол үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн жагсаалт

ХЭСЭГ-2: Зураг төслийн ажлын даалгавар

1. Төслийн тодорхойлолт

1.1 Төслийн зорилго

Энэхүү зураг төслийн ажлын зорилго нь **Монгол улсын ЕБС-ийн хоол үйлдвэрлэл үйлчилгээний орчныг сайжруулах, чадавхыг бэхжүүлэх төсл**ийн хүрээнд сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний байгууламжийг шинэчилж засварлах ажил юм.

2. Зураг төслийн ажлын хүрээ

Гүйцэтгэгч нь дараах зураг төслийн ажил гүйцэтгэх үүрэг хүлээнэ.

(Ажлын шаардлага хэсгийг харна уу):

- Архитектур, инженерийн шугам сүлжээ, цахилгаан болон шаардлагатай бол мэдээлэл холбоо
- Зураг боловсруулах (техникийн ба ажлын зураг) болон техникийн баримт бичиг боловсруулах
- Механик ба Цахилгааны тооцоолол (шаардлагатай бол)
- Тоо хэмжээ ба төсөвт өртөгийн тооцоолол гаргах
- Техникийн шаардлага (Монгол улсын стандарт)

3. Зураг төслийн ажлын үе шат

3.1.1 Техникийн зураг төсөл (зураг төсөл 30% гүйцэтгэх)
3.1.2 Ажлын зураг төсөл (зураг төсөл 100% гүйцэтгэх)
3.1.3 Барилгын ажлын зохион байгуулалт(СМ)-д дэмжлэг үзүүлэх

Зураг төслийн ажлын үеэр зургийн инженерүүд барилгын талбай дээр тогтмол очиж (жишээ нь 7 хоног бүрийн ажлын явцын хуралд оролцох) шаардлагатай мэдээллээр хангана. Барилгын захиалагчийн техник хяналтын болон зохиогчийн хяналтын гэрээ тусдаа хийгдэнэ. Барилгын ажлын явцад зураг төслийн зөвлөгөө, хяналт хийх үйлчилгээг хуулийн дагуу Зургийн Зохиогч үзүүлнэ.

3.1.4 Барилгын зөвшөөрлийн асуудалд дэмжлэг үзүүлэх

Төр захиргааны эрх бүхий байгууллагаас Барилгын ажил эхлүүлэх зөвшөөрөл авахтай холбоотой шаардлагатай бичиг баримтыг Архитектор бүрдүүлж өгнө. (шаардлагатай бол).

4. Зургийн ажлын хуваарь

4.1 Техникийн зураг төслийн ажлын хуваарь:

No.	Зургийн ангилал	Дуусах хугацаа
1	Техникийн зураг төсөл (гүйцэтгэл 30%)	Гэрээ байгуулсан өдрөөс хойш 1 сарын дотор
2	Ажлын иж бүрэн зураг төсөл (гүйцэтгэл 100%)	Гэрээ байгуулсан өдрөөс хойш 3 сарын дотор

* Зураг төслийн гэрээний хугацаа 4 сар, гэвч Гүйцэтгэгч гэрээ байгуулсан өдрөөс 3 сарын дотор Эцсийн байдлаар Зураг төслийг хянаж шалгуулахаар хүргүүлсэн байна.

- **Ерөнхий Хуваарь**

Ажлын үе шат (сараар)	D+1	D+2	D+3	D+4	D+5	D+6	D+7	D+8	D+9	D+10	D+11	D+12	w
Техникийн зураг (BD)													4
Техникийн зургийг БШУЯ, КОЙКА хянана													2
Иж бүрэн ажлын зураг(FD), техникийн шаардлага, төсвийн тооцоолол(BOQ)													6
Нийслэлийн ЭМГ, Онцгой байдлын газраар хянуулах													2
Иж бүрэн ажлын зураг, төсвийн тооцоолол, техникийн шаардлагыг БШУЯ, КОЙКА хянана.													2
Иж бүрэн ажлын зураг, төсвийн тооцооллыг засаж сайжруулах													2
Иж бүрэн ажлын зураг, төсвийн тооцооллыг эцэслэн хянах,													1
БХТ-өөр хянуулан батлуулах													6
Иж бүрэн ажлын зураг, төсвийн													1

тооцооллыг эцэслэн дуусгах																									
Барилгын ажлын гүйцэтгэгч сонгон шалгаруулах																									10
Гэрээ байгуулах																									2
Барилгын ажлын явцын техник хяналт																									12

–

* Дээрх хуваарь урьдчилсан байдлаар гарсан ба барилгын явц болон бусад шалтгаанаас болж өөрчлөгдөж болно.

4.2 Үр дүн / Зураг төслийн бүх бичиг баримтыг монгол, англи хэл дээр ирүүлнэ.

4.2.1 Зураг төслийн ажлын үр дүн, иж бүрдлийн жагсаалт

※ BD: Техникийн зураг төсөл, FD: Ажлын зураг төсөл .

Агуулга			**BD Техникийн зураг**	**FD Ажлын зураг**
Зураг төслийн судалгаа ба тооцоо				
Зураг төслийн судалгаа	• Дүгнэлт (хууль журамд нийцэж буй эсэх)			o
	• ИШС, цахилгаан, сантехник, галын аюулгүй байдал			
				o
Тооцоолол	• ИШС тооцоо : дулааны ачаалал			o
	• Цахилгааны тооцоо: гэрэлтүүлэг, гэрлийн ачаалал			o
Барилга архитектур				
• Зургийн жагсаалт				o
• Товчилсон үг, нэр томьёоны тайлбар				o
• Уналттай таазны байгуулалт				o
• Нураах төлөвлөгөө			o	o

• Давхрын байгуулалт			о	о
• Заслын ажлын хуваарь				о
• Шалны ус тусгаарлалт **(шаардлагатай бол)**			о	о
• Байгуулалт, огтлол ба хэсэглэл				о
• Ханын хэсэг				о
• Давхрын байгуулалтад тусгасан дотор ханын төрөл			о	о
Цонх ба Хаалга	• Түүвэр		о	о
	• Огтлол			о
	• Хэсэглэл			о
	• Тоноглолын түүвэр			о
Хаягжуулалт	• Байгуулалт, түүвэр, хэсэглэл			о
Инженерийн шугам сүлжээ				
• Тоног төхөөрөмжийн түүвэр (гол төхөөрөмжүүд)				о
• Техникийн өрөө, тоног төхөөрөмжийн байгуулалт			о	о
• ИШС ийн схем зураг: Агааржуулалт (хоолой), цэвэр бохирын систем				о
• ИШС ийн схем зураг: Галын систем **(шаардлагатай бол)**				о
• ИШС ийн схем зураг: Эйр – кондишн **(шаардлагатай бол)**				о
• Агааржуулалтын хоолойны давхрын байгуулалт			о	о
• Галын системийн давхрын байгуулалт **(шаардлагатай бол)**				о
• Эйр – кондишны давхрын байгуулалт (хоолойн хамт) **(шаардлагатай бол)**			о	о
• Цэвэр бохирын хоолойн давхрны байгуулалт			о	о
• Автомат хяналтын системын давхрын байгуулалт **(шаардлагатай бол)**			о	о

• Хэсэглэл ба огтлол: Эйр – кондишн ба агааржуулалт (хоолой), цэвэр бохирын систем, автоматжуулалтын систем, галын систем			o
Цахилгаан			
• Гэрэлтүүлэгийн байгуулалт		o	o
• Гэрэлтүүлэгийн түүвэр			o
• Гэрэлтүүлэгийн хэсэглэл			o
• Цахилгаан хангамжийн байгуулалт		o	o
• Инженерийн тоног төхөөрөмжийн цахилгаан хангамжийн байгуулалт		o	o
• Хүчит төхөөрөмжийн тооцооны схем зураг			o
• Хуваарилах самбар ба Дунд хүчдэлийн схем зураг ба хэсэглэл			o
• Давхрын болон хуваарилах самбарын схем зураг ба хэсэглэл.			o
• Хэсэглэлүүд			o
Холбоо дохиолол **(шаардлагатай бол)**			
• Холбоо дохиоллын систем (Telephone/ LAN/ CATV/ CCTV/P.A system) -ийн схем зураг			o
• Холбоо дохиоллын систем (Telephone/ LAN/ CATV/ CCTV/P.A system)-ийн байгуулалт		o	o
• Гадна холбоо дохиоллын байгуулалт		o	o
• Гадна холбоо дохиоллын схем зураг			o
• Нийтийн хаягжилт, каблийн ТВ ийн байгуулалт • Телефон/дотоод сүлжээ/ Кабелийн ТВ/ хяналтын камерийн систем гэх мэт.		o	o
• Давхарын байгуулалт			
Схем зураг • телефон, дотоод сүлжээ, хяналтын камер,нийтийн хаягжилт ба домофон			o
Байгуулалт • телефон, дотоод сүлжээ, хяналтын камер,нийтийн хаягжилтийн систем төлөвлөгөө		o	o
Холболтын схем зураг • Үндсэн холболтын схем зураг			
Холболтын схем зураг • Холболт схем зураг			o
Холболтын схем зураг • Кабелийн түүвэр			o

	• Гадна цахилгаан болон холбоо дохиоллын холболтын схем зураг			
Деталууд	• Түгээлтийн үндсэн хүрээ буюу комьпютерийн төв сервер / бие даасан хуваарилалтын хүрээ буюу самбар, каблийн телевиз, електрон цаг, Хонх, Харилцаа холбооны газардуулга, домофон, Цагаан Хоолой буюу чанга яригч мөн засварын зориулалттай хүн эсвэл гар багтах зай			о
Галын дохиолол / Зарлан мэдээллэх систем **(шаардлагатай бол)**				
Ерөнхий	• Барилгын галын дохиололын схем зураг ба байгуулалт		о	о
	• Барилгын зарлан мэдээлэх системийн схем зураг ба байгуулалт			
Галын системийн шугам хоолой	• Тоног төхөөрөмжийн түүвэр			о
	• Системийн схем зураг			о
	• Галын системийн шугам хоолойны байгуулалт		о	о
	• Хэсэглэл ба огтлол			о
Галын системийн цахилгаан хангамж — Схем зураг	• Галын системийн схем зураг			о
	• Галын системийн мэдрэгч			о
Байгуулалт	• Галын системийн байгуулалт		о	о
	• Зарлан мэдээллэх системийн байгуулалт			
Хэсэглэл	• Галын системийн мэдрэгчийн хэсэглэл			о
	• Зарлан мэдээллэх системын тоноглол, хэсэглэл			

4.2.2 Техникийн зураг төслийн бүрдэл

No.	Агуулга	Хэмжээ	Хувилах тоо	Зургийн багцууд							Жич
				БА	ЕТ	ББ	ЦБУ, ХАС	Цах	ХД	Гал	
1	Зургийн судалгаа тооцоо	А4	3				О	О		О	

2	Ажлын зураг	A3	3	O			O	O		O	
3	CD-нд хуулах		3								

※ Дээрх жагсаалтыг CD-нд хуулж мөн монгол, англи хэлээр 3 хувь, хэвлэмэл хувилж өгнө.

※ Эцсийн байдлаар бүх зураг, бичиг баримтыг өгөхдөө Гүйцэтгэгч гарын үсгээр баталгаажуулж, хариуцсан хүн биечлэн хүлээлгэн өгнө.

※ Дээрх шаардлагыг урьдчилсан байдлаар тодорхойлсон бөгөөд Талууд зөвшилцсөний үндсэн дээр өөрчлөлт оруулж болно.

4.2.3 Иж бүрэн ажлын зураг төслийн бүрдэл

No.	Агуулга	хэмжээ	Хувилах тоо	Зургийн багцууд							Жич
				Архитектур	Барилгын ажил	Газар	Механик	Цах	IT	Гал	
1	Гүйцэтгэлийн тайлан	A4	3	O			O	O	O	O	
2	Ажлын зураг	A1	1	O			O	O	O	O	
		A3	3	O			O	O	O	O	
3	Инженерингийн тооцоо	A4	3	O			O	O	O	O	
4	Төсвийн тооцооллын тайлан	A4	3	O			O	O	O	O	
5	Төсвийн тооцоо	A4	3	O			O	O	O	O	
6	Ажлын тоо хэмжээ	A4	1	O			O	O	O	O	
7	Техникийн шаардлага	A4	3	O			O	O	O	O	
8	CD-нд хуулах		5	O			O	O	O	O	

※ Дээрх иж бүрэн зураг төслийг монгол, англи хэлээр CD-нд (хуулбарлах хувийг тохиролцоно.) хуулж өгнө.

※ Гүйцэтгэлийн тайлан дараах мэдээллийг агуулна. Үүнд : барилга угсралтын ажлын ерөнхий гүйцэтгэл явц, гэрээний хэрэгжилт, зураг төслийн ажлын явц, инженерүүдийн зургийн ажлын гүйцэтгэл, туслан гүйцэтгэгчийн ажлын гүйцэтгэл, техник хяналтын явц,

захиалагчийн техник хяналтын үед хүргүүлсэн үүрэг даалгаварын биелэлт, барилгын материалын сонголт шийдэл, стандарт шаардлагыг хэвлэмэл товхимол зэрэг болно.

※ Ажил дуусахад иж зураг төсөл болон баримт бичигт хариуцсан инженерүүд гарын үсгээр баталгаажуулж хүлээлгэн өгнө.

※ Эдгээр асуудлыг талууд хэлэлцэн тохиролцсоны үндсэн дээр өөрчилж болно.

5. Зураг төслийн ажил гүйцэтгэх заавар

А. Ерөнхий зүйл

1) Гэрээнд гарын үсэг зурсан дариуд гүйцэтгэгч 7 хоногийн дотор ажил эхэлсэн тухай тайланг гаргаж өгөх шаардлагатай. Тайланд дараах мэдээллийг агуулна. Үүнд :
   - Ажил эхэлсэн тухай мэдэгдэл
   - Зураг төслийн ажил гүйцэтгэх график төлөвлөгөө
   - Барилгын норм дүрм стандартын судалгаа
   - Зураг төслийн ажил гүйцэтгэх график төлөвлөгөөний дагуу хүлээлгэж өгөх зургийн жагсаалт, иж бүрдэл
   - Тусгай зөвшөөрлийн хуулбар, инженерүүдийн товч танилцуулга, офиссын байршил, туслан гүйцэтгэх байгууллагын мэдээлэл болон инженерүүдийн ажлын хуваарь жагсаалт
2) Гүйцэтгэгч асуудал үүссэн тохиолдолд ажлын явц болон тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх хурал зохион байгуулна. Хурлын нарийн хуваарь, оролцогчдын мэдээллийг гүйцэтгэгч байгууллага тодохойлно. Бүхий л хурлын тэмдэглэлийг баримтжуулж тайланг АМГТГ болон КОЙКА -д хүргүүлнэ.
3) Гүйцэтгэгч гэрээний үнэ болон хугацаанд багтаан Зураг төслийг иж бүрэн гүйцэтгэж хүлээлгэн өгнө.
4) Гүйцэтгэгчийн зураг төсөл боловсруулах ажил нь энэхүү заавар шаардлагад нийцсэн байна. Зураг төсөл нь төслийн хэрэглээ хэрэгцээнд нийцсэн урт хугацаанд ашиглалтын хэвийн ажиллах шаардлагыг хангасан байна. Гүйцэтгэгч нь аливаа нэмэлт зардал гаргахгүйгээр холбогдох стандарт шаардлага болон ашиглалтад бүрэн нийцсэн зураг төслийг боловсруулсан гэдэгтээ баталгаа өгнө. Хэрэв энэ нь зөрчилдсөн тохиолдолд захиалагчтай зөвлөлдөж захиалагчийн зааврааар ажиллана.
5) Гүйцэтгэгч нь захиалагч тал болох АМГТГ болон КОЙКА-тай зөвшилцсөний үндсэн дээр техник эдийн засгийн үр ашигтай шийдэл санал болгож болно.

6) Шаардлагатай тохиолдолд захиалагчийн шийдвэр зөвлөмжийн дагуу энэхүү зааврыг өөрчилж болно.
7) Гүйцэтгэгч нь энэхүү зураг төслийн ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай холбогдох эрх бүхий байгууллагын зөвшөөрөлтэй байна.
8) Гүйцэтгэгч нь зураг төслийн явцад гарсан асуудлыг шийдвэрлэхэд шаардлагатай бүх арга хэмжээг авах үүрэгтэй.
9) Гүйцэтгэгч нь барилгын талбай дээр урьдчилан очиж тухайн талбайн нөхцөл байдлыг шалгах ёстой. Үүнд : давхрын байгуулалт, өндөржилт, хүрээлэн буй орчны нөхцөл, одоо байгаа шугам сүлжээ болон ус хангамж ариутгах татуургын систем, цахилгааны систем зэргийн зураг төсөл тооцооны талаархи мэдээллийг бүрдүүлсэн байна.
10) Зураг төслийн ажлыг Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй норм дүрм стандартын шаардлага, хууль зохицуулалтын баримт бичиг болон энэхүү зургийн даалгавар, зааварт нийцүүлж гүйцэтгэнэ.
11) Гүйцэтгэгч нь зураг төслийг иж бүрэн гүйцэтгэж дуусгахтай холбоотой бүх тооцоо судалгааг хийнэ. Хэрэв зураг төсөл нь эдийн засгийн үр ашиггүй, хэрэглээнд нийцээгүй шийдэлтэй бол гүйцэтгэгч нь нэмэлт ажлын зардал болон нэмэлт хугацаагүйгээр дахин зураг төслийн боловсруулалтын ажлыг гүйцэтгэж, үр ашигтай, ашиглалтын зохистой байдлыг хангана.
12) Гүйцэтгэгч шаардлагатай судалгаа шинжилгээ, тайлан дүгнэлт боловсруулахтай холбогдон гарах бүхий л зардлыг гэрээний үнэнд багтаасан байна.
13) Захиалагч нь шаардлагатай аль ч тохиолдолд гүйцэтгэгчийн ажлын үр дүнг хянаж шалгах, зааж зөвлөх эрхтэй байна.
14) Зураг төсөл болон техникийн баримт бичигт ашиглах хэмжих нэгж нь олон улсын Си систем байна.
15) Бүхий л зураг төсөл болон техникийн баримт бичгийг Англи болон Монгол хэл дээр боловсруулна.
16) Барилга угсралтын ажлын техникийн шаардлага нь зураг төсөл болон ажлын тоо хэмжээ тооцсон техникийн баримт бичигт тусгаагүй аливаа техникийн мэдээллийг заавал тусгасан байна.
17) Гүйцэтгэгч нь иж бүрэн зураг төсөл болон техникийн баримт бичгийг график төлөвлөгөөнд заасан ажил дуусгавар болох хугацаанд хүлээлцсэн байхаар тооцож захиалагчид хянуулахаар хүргүүлнэ.
18) Гүйцэтгэгч нь зураг төсөл болон техникийн баримт бичгийн үнэн зөвийг бүрэн хариуцна. Эдгээр нь талбайн нөхцөл, шаардлагад нийцэхгүй байгаа тохиолдолд Гүйцэтгэгч нь төслийн шаардлагад нийцүүлэх зорилгоор талбайн үзлэг шалгалт хийх ба холбогдох зардлыг бүрэн хариуцна. Ажил хүлээлцсэний дараа

захиалагчаас гаргасан аливаа зургийн ажилтай холбоотой санал гомдлыг шуурхай барагдуулна.

Б. Барилга архитектур

1) Архитектурын зураг, шийдэл нь хүрээлэн буй орчинтойгоо зохицож нийцсэн байна..
2) Барилгын дотор болон гадна талбайд хүмүүс саадгүй зорчих, орц гарцын төлөвлөлт үр ашигтай, эргэлт хөдөлгөөн хийхэд саадгүй байх нөхцлийг хангасан байх.
3) Барилгын орц гарцыг төлөвлөхдөө, барилгын зориулалт, хүчин чадал, байршил болон зэргэлдээ барилгын хөдөлгөөнийг хамааруулан тооцож, хот төлөвлөлтийн барилгын норм дүрэмд заасны дагуу онцгой байдлын үеийн аваарийн гарц, хонгилын шаардлагыг бүрэн хангахаар төлөвлөнө.
4) Гүйцэтгэгч нь барилгын материалыг сонгохдоо тэдгээрийн бат бөх чанар, эдэлгээ даах байдал, үзүүлэлт, өнгө үзэмж, бүтэц, хэв маягийг харгалзана.
5) Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу тогтвортой байдлыг харгалзан үзэх.
6) Бэлгэдэл, өвөрмөц байдлыг харуулахын тулд функциональ чанар болон гоо зүйг хослуулах.

В. Инженерийн шугам сүлжээ

1) Барилгын шинж чанар, ашиглалтын нөхцөл, шаардлагыг бүрэн судалж агааржуулалт, цахилгаан угсралтын ажлын төлөвлөлтийг гүйцэтгэх.
2) Агааржуулалтын хүчин чадал, суурилуулын аргыг тодорхойлох
3) Цахилгаан тэжээл болон бусад залгуурын байршлыг технологийн байгуулалт, инженерийн шугам сүлжээний тоног төхөөрөмжийн байгуулалттай уялдуулж өрөө тус бүрийн зориулалтад нийцүүлж төлөвлөнө.
4) Цахилгаан тоног төхөөрөмж нь цахилгааны газардуулгатай байна.

6. Гүйцэтгэгчийн Хариуцлага

Гэрээтэй холбогдуулан гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагын хэсэг болгох нь:

1) Гүйцэтгэгч нь зураг төслийн ажлын хяналтыг бүрэн хариуцна.
2) Төсөлтэй холбоотой шаардлагатай мэдээлэл, гарын авлага, тоон үзүүлэлт тайлан боловсрулах.
3) Төрөл бүрийн зөвшөөрөл авахад захиргааны туслалцаа үзүүлэх, гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой бүхий л асуудлаар харилцах Төлөөлөгчийг томилно.
4) Баталгаа, хадгаламжийн барьцаа: Гүйцэтгэгч нь Монгол улсын Төрийн худалдан

ажиллагааны журмыг баримтлана.(Хадгаламжийн барьцаа нь Монгол Улсын банк эсвэл Засгийн газрын бондын баталгаа болно..)

7. Нууцлал

1) Гүйцэтгэгч нь нууцлалыг хадгалахыг зөвшөөрч мөн бүх туслан гүйцэтгэгч нар нь өгөгдсөн мэдээлэл, төсөлтэй холбоотой баримт бичгийн нууцыг хадгалахыг хариуцна. Гүйцэтгэгч нь өөрийн бүх үүрэг, хариуцлагыг биелүүлэхийн тулд дараах зөвшөөрөгдсөн тохиолдлуудаас бусад тохиолдолд ямар нэгэн шалтгаанаар гуравдагч этгээдэд мэдээлэл задруулахгүй.

2) Дараахь зүйлд заасан мэдээлэл, баримт бичгийн нууцыг хадгалах хариуцлагаас чөлөөлөгдөнө.

- Энэ мэдээлэл, баримт бичгийг хүлээн зөвшөөрөхөөс өмнө Гүйцэтгэгчийн эзэмшилд байгаа эсвэл олон нийтийн мэдэлд байгаа.
- Захиалагчийг хохироож болзошгүй мэдээллээс бусад болон аль хэдийн олон нийтэд мэдэгдэж байгаа эсвэл мэдэгдэх гэж байгаа тохиолдолд Гүйцэтгэгч буруугүй болно.

(Хөгжлийн албан ёсны тусламжийн төслийн Авлигын эсрэг тунхаглал)

☐ Төслийн нэр: Монгол улсын ЕБС-ийн хоол үйлдвэрлэл үйлчилгээний орчныг сайжруулах, чадавхыг бэхжүүлэх төсөл

Манай компанийн ажилтнууд болон төлөөлөгчид төслийн гэрээнд оролцохтой холбогдуулан дараах зүйлийг мэдэгдэж байна.

1. “Олон улсын төрийн албан хаагчид олон улсын бизнесийн хэлцэл хийхдээ хээл хахууль авахтай тэмцэх тухай хууль” (2018 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 15972 дугаар хууль)-ийг бүрэн ойлгож байгаа бөгөөд хуулиар зохицуулсан заалтуудыг чанд мөрдөж ажиллана.

2. Бид аль ч шүүхийн харьяалал нутаг дэвсгэрт (сүүлийн 5 жилийн хугацаанд) гадаад дахь хээл хахуулийн хэргээр буруутгагдаж байгаагүй бөгөөд цаашид ч ийм үйлдэл гаргахгүй.

3. Бид өөрийн ажилтнуудад бусадтай харилцан тохиролцох зэрэг шударга бус үйлдэл гаргахыг зөвшөөрөхгүй, КОЙКА-тай холбоотой ажилтнууд болон гадаад орны төрийн албан тушаалтнуудад авлига, хээл хахууль (мөнгө, тансаг зугаа цэнгэл, тэр дундаа хамаатан садан болон бусад хүмүүсийг шударга бусаар ажилд авах гэх мэт)) өгөхгүй.

4. Бид гэрээг шударгаар хэрэгжүүлэх, авлига хээл хахуулиас урьдчилан сэргийлэх дотоод хяналтын журам, компанийн ёс зүйн дүрэм, хяналтын тогтолцоотой болж, шүгэл үлээгчдийг ямар нэг хэлбэрээр шийтгэхгүй байх бодлогыг хэрэгжүүлэхийн төлөө ажиллана.

5. Бид зөвлөх үйлчилгээний гэрээ/худалдан авах ажиллагааны гэрээ/барилга угсралтын гэрээг чин шударгаар гүйцэтгэж, залилан мэхлэх зэргээр хангалттай үндэслэл үүсээгүй тохиолдолд гэрээгээ биелүүлэхгүй байх зэрэг хариуцлагагүй үйлдэл гаргахгүй байхаа амлаж байна.

6. Манай компани дор дурдсан зөрчлийн ангилалд хамаарах аливаа үйл ажиллагаа эрхэлж байгаа эсвэл КОЙКА-аас авсан хориг арга хэмжээнд хамрагдсан тохиолдолд КОЙКА-ийн төслүүдэд хоёр жил хүртэлх хугацаанд оролцохыг хориглох зэргээр КОЙКА-ийн зүгээс авсан аливаа хориг арга хэмжээг бид эсэргүүцэхгүй гэдгээ мэдэгдэж байна.

а. Гэрээтэй холбоотой баримт бичгүүдэд худал мэдэгдэл оруулсан
б. Анхаарал хайхрамжгүй байдал гаргасан
в. Туслан гүйцэтгэх гэрээг зүй бусаар байгуулсан
г. Судалгаа, зураг төсөл, техник эдийн засгийн үндэслэлийн чанар хангалтгүй
д. Гэрээг зөрсөн
е. Олон нийтэл хохирол юм уу гэмтэл бэртэл учруулсан
ё. Үйл ажиллагаанд оролцож буй хүнд хохирол юм уу гэмтэл бэртэл учруулсан
ж. Авлига өгсөн
з. Тендерт оролцохдоо хуйвалдсан
и. Тендер ба Гэрээ байгуулах явцад хөндлөнгөөс оролцсон
й. Зүй бус эсвэл шударга бус үйлдэл гаргасан

7. Бид гэрээг хэрэгжүүлэхдээ ОУХБ-ын (Олон улсын хөдөлмөрийн байгууллага) холбогдох стандартууд болон КОЙКА-гийн хүний эрхийн менежментийн зарчимд нийцүүлэн ажиллахаа амлаж байна.

8. Бид ажлын байр бий болгох, нийгэмд интеграци бүхий тэгш боломж, хөгжил цэцэглэлтийн төлөөх хамтын ажиллагаа, ёс зүйн менежмент зэрэг нийгмийн үнэт зүйлсийг эрхэмлэн дээдэлж, гэрээг хэрэгжүүлэх явцад эдгээр үнэт зүйлсийг бодитой болгохын төлөө чармайн ажиллахаа амлаж байна.

Огноо: 2023 оны 11-р сарын ...-ны өдөр

Компанийн нэр:

Ерөнхий захирал эсвэл Төлөөлөгч: ----------

Гарын үсэг